

Дугаржавын Цэрэн багшийн “Электронд” шүлгийг англи хэл рүү хөрвүүлэх уралдааны дүн гарлаа



Монголын нэрт физикч, соён гэгээрүүлэгч, авъяаслаг орчуулагч, Дугаржавын Цэрэн электроныг нээсний 90 жилийн ойг тохиолдуулан 1987 онд анх “Электронд” шүлгээ бичсэн цагаас хойш өдгөө 36 жил болжээ. 2022 онд Д.Цэрэн багшийн мэндэлсний 90 жилийн ой тохиож, түүний үр хүүхдүүд, физикчид тэмдэглэн өнгөрүүлсэн юм. Энэ ойн арга хэмжээний хүрээнд ШУА -ийн Физик, технологийн хүрээлэнд Д.Цэрэн багшийн нэрэмжит танхимийг нээсэн юм.

Мөн онд “Д.ЦЭРЭН БАГШ Амьдрал, Эрдмийн найман зам” нэртэй номын 2 дахь хэвлэлийг түүний дүү Д.Цэрэнханд, хүү Физик-математикийн ухааны доктор (PhD) Ц.Даваадорж нар эмхэтгэн гаргасан юм.

Монголын үе үеийн физикчид “Цэрэнгийн ФИЗИК” гэж алдаршсан сурах бичгээр физикийн шинжлэх ухаанд шимтэн суралцаж, мэдлэг оюунаа тэлсэн байдаг.


2023 оны 11-р сарын 03-ны өдөр зохион байгуулагдсан Монголын Физикийн Нийгэмлэгийн хурлын үеэр Д.Цэрэн багшийн гэр бүл, үр хүүхдүүдээс “Электронд” шүлгийг англи хэлнээ хөрвүүлэх уралдаан зарласан билээ. Тус уралдаанд олон эрдэмтэд өөрсдийн орчуулсан хувилбараа илгээснээс:

1-р байранд Физик, технологийн хүрээлэнгийн Онол болон Их Энергийн Физикийн Лабораторийн эрхлэгч, доктор Ц.Энхбат,

2-р байранд Физик, технологийн хүрээлэнгийн ЭША, физикч Л.Бямбажаргал

3-р байранд Профессор С.Лодойсамба

нар шалгарлаа.



Д.Цэрэн (1987)

ЭЛЕКТРОНД

Эгэл бөөмсийн тэргүүн
 Электрон чи сайн уу?
 Эргэлдэн бүжиж олсон
 Спин чинь хэвээр үү?

Поль Диракийн ижилсүүлсэн
 Позитрон чинь байгаа юу?
 Эрвин Шредингерийн бичсэн
 Эрхийн үнэмлэх чинь бий юу?

Макс Борны өмсгөсөн
 Магадлалын хүрэм чинь шинээр үү
 Тонгочих хоёр төлөвтэй
 Тогтнох олон төлөвтэй

Атомын дотор байхдаа
 Амар тайван боловч
 Хил хязгаарт явахдаа
 Химийн холбоо үүсгэсэн

Өдөөсөн фотоныг сугадаад
 Өндөр суудалд гарснаа
 Лагшин тогтож буухдаа
 Лазерийн туяа цацруулсан

Эгэл бөөмсийн тэргүүн
 Электрон чи сайн уу?

TO THE ELECTRON

Hail to the Electron for he reigns
 The realm of elementary particles
 A swirling dance gave you the spin
 Do you still possess it within?

Paul Dirac found your companion
 How is she nowadays, your positron?
 Erwin Schrödinger wrote your mandate
 Isn't it still your certificate?

Does it shine anew
 That probability cloak you've worn?
 Like when it was thrown
 Upon you by Max Born?
 Topsy-turvy two states you room
 Towering many states you roam

Inside an atom
 It is always calm
 Yet when you are at a periphery
 You create that bond of chemistry

Swooned by an exciting photon
 To a high state of lofty throne
 Yet tranquility soon returns again
 With the emission of the laser's rain

Hail to the Electron for he reigns
 The realm of elementary particles.

Орчуулсан доктор Ц. Энхбат